



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/34

Ханх сум

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ─┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Турт 3-р багийн иргэн Б.Оюунтуяагийн 5*6 хэмжээтэй 4*5 залгаатай байшин 2024 оны 06 дугаар сарын 16-ны 23:00 цагийн үед шатсан тул хохирлын үнэлгээ хийх ажлын хэсэг томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Ичинноров (Байгаль хамгаалагч)

Гишүүд: Э.Алтангэрэл (Мал эмнэлгийн улсын байцаагч)

М.Эрдэнэсүрэн (Халамж, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн)

Х.Пүрэвдорж (Засаг даргын Тамгын газрын Галч)

Нарийн бичгийн дарга: М.Жавзан (Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Шатсан эд хөрөнгө, бичиг баримтыг үнэн зөв бүртгэж хууль журмын дагуу хохирлын үнэлгээ хийж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн мэргэжилтэн (О.Золзаяа)-д даалгасугай.

ДАРГА



Л.ДАВААБАЯР